

Нууцлалын бодлого

Сүүлд шинэчлэгдсэн 2025/01/30

Ерөнхий

Энэхүү Нууцлалын бодлого нь Монгол Улсын Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд үндэслэн Хэрэглэгчийн хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулна.

“Цахим Дижитал Гараж” ХХК (“Мэдээлэл хариуцагч”) нь Хэрэглэгч (“Та” эсхүл “Хэрэглэгч”)-ийг “Дижитал Гараж” цахим авто үйлчилгээний худалдааны www.garage.mn вебсайт болон Digital Garage аппликейшн (“Digital Garage”)-д бүртгүүлж, ашиглах үед Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу Таны хувийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглах бөгөөд мэдээллийн аюулгүй байдлыг хангана.

Хэрэглэгч “Digital Garage”-д бүртгүүлэхээс өмнө энэхүү “Нууцлалын бодлого”-той бүрэн танилцах үүрэгтэй.

Та “Нууцлалын бодлого”-д заасан нөхцөлүүдийг бүрэн хүлээн зөвшөөрч, “**Би хүлээн зөвшөөрч байна.**” гэсэн товчийг идэвхжүүлснээр “Digital Garage”-г ашиглах явцад өөрийн хувийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглах цахим зөвшөөрлийг Мэдээлэл хариуцагчид олгосонд тооцно.

Хэрэв Та “Нууцлалын бодлого”-д заасан нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан тохиолдолд “Би татгалзаж байна” гэсэн товчийг идэвхжүүлэх боломжтой. Энэ тохиолдолд Мэдээлэл хариуцагч таны мэдээллийг цуглуулахгүй, боловсруулахгүй, ашиглахгүй тул “Digital Garage”-г зориулалтын дагуу бүрэн ашиглах боломжгүй болохыг анхаарна уу.

Энэхүү Нууцлалын бодлогоор зохицуулаагүй харилцааг Монгол Улсын Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар зохицуулна.

1. Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үндэслэл, зорилго

“Цахим Дижитал Гараж” ХХК-н авто үйлчилгээний худалдааны вебсайт болон аппликейшн нь дараах тохиолдлуудад иргэн, хуулийн этгээдийг /цаашид “Хэрэглэгч”, “Захиалагч” гэх/ мэдээллийг цуглуулна. Үүнд:

- 1.1 Мэдээлэл хариуцагч Хэрэглэгчээс олгосон цахим зөвшөөрлийг үндэслэн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглана.
- 1.2 “Digital Garage”-ийн тасралтгүй, найдвартай, хэвийн ажиллагааг хангах, системийг хөгжүүлэх, Хэрэглэгчийн хүсэл, сонирхолд нийцсэн, хялбар, энгийн шийдэл бүхий үйлчилгээг санал болгох зорилгоор Хэрэглэгчийн хувийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглана. Мэдээлэл хариуцагч энд зааснаас өөр зорилгоор мэдээллийг цуглуулахгүй, ашиглахгүй, дамжуулахгүй.
- 1.3 Энэхүү “Нууцлалын бодлого”-д заасан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.3.1 “Мэдээлэл цуглуулах” гэж мэдээллийг олж авах, бүрдүүлэх, бүртгэх үйл ажиллагааг;

- 1.3.2 “Мэдээлэл боловсруулах” гэж мэдээллийг ангилах, хадгалах, дүн шинжилгээ хийх, Хэрэглэгчийн хүсэлтээр өөрчлөх, устгах, сэргээх үйл ажиллагааг;
- 1.3.3 “Мэдээлэл ашиглах” гэж үйл ажиллагаандаа хэрэглэх, дамжуулах болон мэдээлэлтэй танилцах үйл ажиллагааг;
- 1.4 Мэдээлэл хариуцагч Хэрэглэгчийн мэдээллийг цуглуулж, боловсруулах, ашиглах ажиллагаанд Таны мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй байх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарчмуудыг баримтална.
- 1.5 Хэрэглэгч өөрт хамааралтай мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах бөгөөд мэдээллийн дутуу эсхүл зөрүүтэй оруулснаас үүдэх эрх зүйн үр дагаврыг бие даан өөрөө хариуцна.

2. Мэдээлэл хариуцагчийн холбоо барих мэдээлэл

- 2.1 Мэдээлэл хариуцагч Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан “Цахим Дижитал Гараж” ХХК байна.
- 2.2 Хэрэглэгч энэхүү Нууцлалын бодлогын нөхцөл, хэрэгжилттэй холбоотой асуудлаар info@garage.mn цахим шуудангаар, санал, хүсэлт, гомдлоо шийдвэрлүүлнэ.

3. Цуглуулж, боловсруулж, ашиглах мэдээллийн жагсаалт

- 3.1 Мэдээлэл хариуцагч “Digital Garage”-ийн тасралтгүй, найдвартай, хэвийн ажиллагааг хангах, Хэрэглэгчид бүрэн ашиглах боломжийг олгох хүрээнд дараах мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглана. Үүнд:
 - 3.1.1 Хэрэглэгчийн овог, нэр, иргэний бүртгэлийн дугаар, төрсөн огноо, нас, хүйс оршин суугаа хаяг, шуудангийн хаяг, цахим гарын үсэг, захиалгын мэдээлэл, захиалгын үйл явц, банкны дансны дугаар, кредит болон дебит картын дугаар, захиалгын баталгаажилт, холбоо барих утасны дугаар, захиалгын болон гүйлгээний түүх, аватар зураг бүхий мэдээллүүд;
 - 3.1.2 Хэрэглэгчийн зээлийн мэдээлэл, зээл эргэн төлөлт, түүхийн мэдээллүүд;
 - 3.1.3 “Digital Garage” дээр хийгдсэн гүйлгээнд хамаарах хүлээн авагчийн нэр, мөнгөн дүн, шилжүүлгийн огноо, гүйлгээний баталгаажилтад хамаарах мэдээллүүд;
 - 3.1.4 “Digital Garage”-г хэрэглэх явц үүсэж буй бүртгэлийн, хэтэвчний мэдээлэл, таалагдсан барааны болон бусад цахим өгөгдлүүд;
 - 3.1.5 Хэрэглэгчийн хүсэлт, санал, гомдол, түүнийг шийдвэрлэх явц, үр дүнгийн талаарх мэдээллүүд;
- 3.2 Мэдээлэл хариуцагч “Digital Garage”-ийн програм хангамжийг хөгжүүлэх, мэдээлэл технологийн шинэ шийдэлд тулгуурласан энгийн, хялбар, хэрэглээг бий болгох, хууль бус хандалтаас урьдчилан сэргийлэх хүрээнд дараах мэдээллийг цуглуулна. Үүнд:
 - 3.2.1 IP хаягийн мэдээлэл, веб хөтөч, ашиглаж буй үйлдлийн систем, “Digital Garage”-ийн бүртгэлийн хаягт нэвтэрсэн хугацаа, газар зүйн байршлын мэдээллүүд;
 - 3.2.2 Хэрэглэгчийн цахим гарын үсэг, цахим тодорхойлогчийн мэдээллүүд;
 - 3.2.3 Cookies файлын тусламжтайгаар автоматаар цуглуулж буй мэдээллүүд болох цахим орчинд хандсан эх сурвалжуудын мөрнүүд;

4. Хэрэглэгчийн мэдээллийг боловсруулах, ашиглах нөхцөл, хугацаа

- 4.1 Мэдээлэл хариуцагч Хэрэглэгчийн мэдээллийг дараах тохиолдолд боловсруулж, ашиглана. Мэдээлэл хариуцагч дор дурдсан нөхцөлөөс бусад хэлбэрээр Хэрэглэгчийн мэдээллийг боловсруулж, ашиглахгүй болно Үүнд:
 - 4.1.1 Захиалгатай бараа бүтээгдэхүүнийг хүргэх, захиалгатай холбоотой тодруулах зүйл гарсан тохиолдолд;
 - 4.1.2 Таны гар утсанд холбогдох цахим шууданд мэдэгдэл, мэдээлэл илгээх;
 - 4.1.3 Хэрэглэгчийн бүртгүүлсэн хаягаар хүргэлтийн үйл ажиллагаанд ашиглах;
 - 4.1.4 Хэрэглэгчийн танин, баталгаажуулах үед;
 - 4.1.5 Хэрэглэгчээс ирүүлсэн гомдлыг хянан шалгах явцад;
 - 4.1.6 “Digital Garage”-ийн мэдээллийн аюулгүй байдлыг хяналтыг сайжруулах, түүнд холбогдох тест хийх;
 - 4.1.7 “Digital Garage”-д програм хангамжийн хөгжүүлэлт хийж, түүнийг тестлэх ажиллагаанд;
 - 4.1.8 “Digital Garage”-д нэвтрүүлж байгаа шинэ бүтээгдэхүүн, болон модуль хөгжүүлэлтэд тест хийх;
 - 4.1.9 Техникийн засвар хийх үед;
 - 4.1.10 “Digital Garage” хэрэглэгчийн судалгаа ба хяналтад зориулж нийт хэрэглэгч, захиалга г.м
 - 4.1.11 Хэрэглэгчид шинэ бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, хямдралын мэдээллийг хүргэх зориулалтаар;
 - 4.1.12 Хэрэглэгчид “Албан ёсны борлуулагч” нарын санал болгож буй шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний хямдралын мэдээллийг хүргэхэд.
- 4.2 Мэдээлэл хариуцагч Хэрэглэгчийг “Digital Garage”-д бүртгүүлснээс эхлээд бүртгэлийг хаах хүртэлх хугацаанд мэдээллийг боловсруулж, ашиглана.
- 4.3 Мэдээлэл хариуцагч Хэрэглэгчийн хувийн халдашгүй байдлыг хүндэтгэн дээдлэх бөгөөд “Digital Garage”-ийн бүртгэлийн мэдээллийг Монгол Улсын Засгийн газраас баталсан кибер аюулгүй байдлын журамд заасан хугацаагаар хадгална.
- 4.4 Мэдээлэл хариуцагч Хэрэглэгчийн системд оруулсан мэдээллийг Amazon EC2 дэх өөрийн серверт хадгална. Хэрэглэгч системд нэвтрэх нэр, нууц үгийг бусдад задруулахгүй байх үүрэгтэй.
- 4.5 Нэвтрэх эрхээ бусдад алдсанаас үүдэлтэй Хэрэглэгчийн хуудаст үүссэн аливаа хор, хохирлыг Мэдээлэл хариуцагч хариуцахгүй болно. Мэдээлэл хариуцагч Хэрэглэгчийн хандах эрхийг ашиглан мэдээлэлд нэвтрэх боломжгүй болохыг анхааруулж байна.
- 4.6 Бид өөрсдийн үйлчилгээг сайжруулах зорилгоор “Digital Garage”-ийн лавлах утсанд холбогдсон дуудлагын аудио бичлэгийг хуульд заасан хугацаагаар хадгална.

5. Хэрэглэгчийн мэдээллийг нийтэд ил болгох нөхцөл

- 5.1 Монгол улсын хуульд заасан тохиолдолд төрийн эрх бүхий байгууллагын шаардлагаар Хэрэглэгчийн мэдээллийг нийтэд ил болгоно.
- 5.2 Мэдээлэл хариуцагч Нууцлалын бодлогын 5.1-д зааснаас бусад тохиолдолд Хэрэглэгчийн хувийн мэдээллийг нийтэд ил болгохгүй.

6. Хэрэглэгчийн мэдээллийг дамжуулах журам

- 6.1 Хэрэглэгчийн мэдээллийг дараах тохиолдолд дамжуулна. Үүнд:
 - 6.1.1 Хэрэглэгчийн хүсэлтээр зээлээр эсхүл дараа хуваан төлөх нөхцөлтэйгөөр бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах тохиолдолд Зээлдүүлэгчийн шаардсан Хэрэглэгчийн зээлийн судлахад хамаарах мэдээллийг

дамжуулна. Хэрэглэгч Та энэхүү Нууцлалын бодлогын зөвшөөрсөн тохиолдолд Зээлдүүлэгчид дээрх мэдээллийг дамжуулах зөвшөөрлийг Мэдээлэл хариуцагчид олгосонд тооцно.

- 6.1.2 Албан ёсны борлуулагчийн хүсэлтээр зөвхөн түүний худалдсан бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой Хэрэглэгчийн мэдээлэлтэй танилцана.
- 6.1.3 Мэдээлэл хариуцагч Таны хувийн мэдээллийг гуравдагч этгээд ашиг олох зорилгоор дамжуулахгүй, түгээхгүй, худалдахгүй бөгөөд үйлчилгээний хэрэгцээнээс гадуур аливаа ашиг олох зорилгоор ашиглахгүй болно.
- 6.1.4 Мэдээлэл хариуцагчаас томилсон эрх бүхий албан тушаалтан Таны хувийн мэдээлэлд хандах эрхтэй. Эрх бүхий албан тушаалтан Таны хувийн мэдээллийг гуравдагч этгээдэд задруулах эсхүл өөрийн хувийн сонирхолд нийцүүлэн нээлттэй бус мэдээллийг задруулахыг хатуу хориглоно. Хориглосон зохицуулалтыг зөрчсөн эрх бүхий албан тушаалтан хууль зүйн хариуцлага хүлээнэ.

7. Хэрэглэгчийн хувийн халдашгүй байх эрхийн хамгаалалт

- 7.1 Хэрэглэгч “DigitalGarage” дахь мэдээлэл болон өөрийн дансныхаа тохиргоог хэдийд ч өөрчлөх эрхтэй.
- 7.2 Хэрэглэгч хувийн халдашгүй байх эрхээ хэрэгжүүлэх хүрээнд Мэдээлэл хариуцагчид олгосон мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглуулах зөвшөөрлөө хэдийд ч цуцлах эрхтэй бөгөөд энэ хүсэлтийн хамт Мэдээлэл хариуцагчид хадгалагдаж буй өөрийн мэдээллийг устгуулах хүсэлт гаргах эрхтэй. Зөвшөөрлийг цуцлах хүсэлт болон өөрийн мэдээллийг усгуулах хүсэлтийг info@garage.mn хаягаар илгээж, шийдвэрлүүлнэ.
- 7.3 Хэрэглэгчийн дээрх цуцлах хүсэлтийг ажлын 3-5 хоногийн дотор судалж, “Digital Garage”-оос бүртгэлийг, өөрийн мэдээллийг устгуулах хүсэлтийг нэмж гаргасан бол холбогдох мэдээллийг устгаад хариу мэдэгдэнэ. Улмаар “Digital Garage” Таны мэдээллийг дахин цуглуулахгүй, боловсруулахгүй, ашиглахгүй болно.
- 7.4 Хэрэглэгчийн хүсэлтээр түүний мэдээлэлд өөрчлөлт оруулах, засах арга хэмжээг зохион байгуулна.
- 7.5 Кибер халдлага, эрх бүхий албан тушаалтны алдаатай үйл ажиллагаа, эсхүл програм хангамж болон мэдээллийн санд гэмтэл гарсны улмаас Таны хувийн мэдээлэл алдагдсан тохиолдолд Мэдээлэл хариуцагчаас таны бүртгүүлсэн и-мэйл хаяг, гар утасны дугаарт нэн даруй мэдэгдэл хүргүүлнэ. Та мэдэгдэлд заасан арга хэмжээг заавар, анхааруулгыг дагуу авах үүрэгтэй.

8. Нууцлалын бодлогын нэмэлт, өөрчлөлт

- 1. Мэдээлэл хариуцагч Нууцлалын бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй. Нууцлалын бодлогод өөрчлөлт оруулсан тохиолдолд тухай бүр www.garage.mn сайт болон Digital Garage аппликэйшн дээр нийтэд нээлттэй нийтлэх бөгөөд Хэрэглэгч танилцах үүрэг хүлээнэ.
- 2. Хэрэглэгчийг захиалга хийгдэх үед хүчинтэй байсан “Нууцлалын бодлого” захиалгыг хүргэх шатанд өөрчлөгдсөн тохиолдолд өмнөх “Нууцлалын бодлого”-г бараа бүтээгдэхүүнийг хүлээж авах хүртэлх хугацаанд хүчинтэйд тооцно.